



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/138

Есенбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7, 29 дүгээр зүйлийн 29.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн 3.9, 7.2.4 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1.1, 3.1.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн газрын компьютерийн хүчин чадлыг сайжруулахад шаардагдах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Компьютерийн хүчин чадал сайжруулахад шаардагдах 6.800.000 (Зургаан сая найман зуун мянган) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т, шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж Амгаланбаатар)-т тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

8200010223